



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023 | VIII



ГАРЧИГ

Нийгмийн үзүүлэлт:

I.	Ажлын байрны зуучлал.....	3
II.	Бүртгэлтэй ажил хайгч иргэд.....	3
III.	Нийгмийн даатгал.....	4
IV.	Эрүүл мэнд.....	5
V.	Гэмт хэрэг.....	6

Эдийн засгийн үзүүлэлт:

I.	Мөнгө, банк.....	8
II.	Төсөв.....	9
III.	Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ.....	10
IV.	Аж үйлдвэр.....	11


Хавсралт хүснэгтүүд

Шинэ ажлын байранд 578 хүн зуучлагджээ




Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 8 сарын мэдээгээр нийт 578 хүн ажлын байранд зуучлагджээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 70 хүнээр өсжээ. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 297 буюу 51.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 1. АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭДИЙН ТОО, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ХАА-ын салбарт 39.0 хувь, боловсролын салбарт 7.0 хувь, уул уурхай олборлох үйлдвэрийн салбарт 3.0 хувь, төрийн удирдлагын салбарт тус бүр 19.0 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 8.0 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 5.0 хувь, бусад салбарт 19.0 хувь нь зуучлагджээ.

ЗУРАГ 2. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, эдийн засгийн салбараар, хувиар




Бүртгэлтэй ажил хайгч 229 иргэн байна



2023 оны 8 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 229 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.0 хувиар буурсан байна. Нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 58.1 хувь буюу 133 нь эмэгтэйчүүд байна. Тус аймгийн хувьд 10000 хүнд ногдох ажил хайгч иргэдийн тоо 70 байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, жил бүрийн эхний 8 сарын байдлаар




Нийгмийн даатгалын сангийн орлого 1.4 тэрбумаар өссөн байна




Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2023 оны 8 сарын байдлаар 42.5 тэрбум төгрөг, зарлага 41.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 1.4 тэрбум төгрөгөөр буюу 3.5 хувиар, зарлага 2.1 тэрбум төгрөг буюу 5.4 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2023 оны 8 сарын байдлаар 9314 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2424 хүн буюу 26.0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 3848 хүн буюу 41.3 хувь нь төсөвт байгууллагаас, 3042 хүн буюу 32.7 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, аж ахуй нэгж байгууллагын даатгуулагч өсч, төсөвт байгууллагын даатгуулагч, сайн дурын даатгуулагч тус тус буурсан байна

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ /хувиар/



ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ /хувиар/



Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2023 оны 8 сарын байдлаар 32.0 тэрбум төгрөг болж, үүний 86.5 хувийг өндөр настны, 7.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.3 хувийг тэжээгчээ алдсаны, 3.4 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Эхний 8 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хүн 8350 байна. Нийт тэтгэвэр авагчдын 85.7 хувь буюу 7160 хүн өндөр насны, 9.6 хувь буюу 802 хүн тахир дутуугийн, 2.7 хувь буюу 225 хүн тэжээгчээ алдсаны, 2.0 хувь буюу 163 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Эхний 8 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 1324, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 17, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 175 хүн байна.

Тухайн сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 12110 байгаагийн 63.2 хувь буюу 7656 төр хариуцах иргэд, 27.5 хувь буюу 3336 малчид, 1.1 хувь буюу 128 оюутан суралцагсад, 8.2 хувь нь буюу 990 аж ахуй нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.


Төрөлт өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өссөн байна




Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2023 оны 8 сарын байдлаар 472 эх төрсөн ба нийт 475 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар буюу 30 төрөлтөөр өссөн байна. Төрсөн эхчүүдийн 94.9 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт 8 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн 4 эндэгдэл бүртгэгдсэн байна. Нас баралтын 151 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор буурсан. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 48 буюу 31.8 хувийг эзэлж байна.

Тухайн жилийн эхний 8 сарын байдлаар стационарит шинээр 6981 эмчлүүлэгч хэвтэж, 6970 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 50999 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.3 байна.

ЗУРАГ 6. ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО



ЗУРАГ 7. ЭМЧЛЭГДЭЖ ГАРСАН ХҮНИЙ ТОО




2023 оны жилийн эхний 8 сарын байдлаар 114477 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 21.8 хувь, өвчний учир амбулаторийн үзлэг 64.2 хувь, идэвхтэй хяналт 8.6 хувь, гэрийн идэвхтэй үзлэг 4.1 хувь, гэрийн дуудлагын үзлэг 1.3 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 34.3 хувь нь эрэгтэй, 65.7 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 374 тохиолдол бүртгэгдээд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 70.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 3007 тохиолдол буюу 634.2 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 185 болж өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буурчээ.



Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2023 оны эхний 8 сарын байдлаар иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1061 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 130(10.9%-)р буурсан байна. 2023 оны эхний 8 сард улсын хэмжээнд 25392 гэмт хэрэг бүртгэгдсэний 185(0.7%) нь Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеэс 11(5.6%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 8. 2023 ОНЫ ЭХНИЙ 8 САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ / Өмнөх 2 оны мөн үетэй харьцуулснаар/



Бүртгэгдсэн нийт 185 гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнийг санаатай алах гэмт хэрэг гараагүй байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8(12.3%) хэргээр, хулгайлах гэмт хэрэг 3(8.1%) хэргээр, дээрэмдэх гэмт хэрэг 1(2 дахин) хэргээр, залилах гэмт хэрэг 2(7.4%) хэргээр, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг 2(2 дахин) хэргээр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4(26.7%) хэргээр өссөн бол хүчиндэх гэмт хэрэг 2(40.0%) хэргээр, мал хулгайлах гэмт хэрэг 8(80.0%) хэргээр, хүнийг санаатай алах гэмт хэрэг 5(5 дахин) хэргээр, бусад гэмт хэрэг 11(42.3%) хэргээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5(5 дахин) хэргээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас 10 хүн нас барж, 193 иргэн хохирч, 86 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо 9(11.7%) хүнээр өссөн бол хохирсон хүний тоо 17(8.1%) хүнээр, нас барсан хүний тоо 2(16.6%) хүнээр буурсан байна.

Гэмт хэрэгт нийт 126 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7(5.3) байна.

Нийт гэмт хэргийн 43(23.2%) нь согтуугаар, 22(11.9%) нь эмэгтэй хүн оролцсон, 7(3.8%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн, 5(2.7%) нь хүүхэд оролцсон, цахим орчинд үйлдэгдсэн 17(9.2%), бүлэглэн гүйцэтгэсэн 3(1.6) гэмт хэрэг байна.

ЗУРАГ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДЛААР /Нийт гэмт хэрэгт эзлэх хувиар/



Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 8 сарын байдлаар 13218 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 137 зөрчлөөр буурсан үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 12857 иргэнийг 626.4 сая төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 213 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасаж, 134 хүнд баривчлах, 47 хүнд саатуулах шийтгэл ногдуулсан байна.

Нийт 31 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 178(6.7 дахин) хүнээр буурсан байна.


Банкны хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсжээ



Тус аймагт нийт 34 банкны салбар нэгжид 160 хүн ажиллаж байна. Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар өсч, 165.9 тэрбум төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1.5 тэрбум төгрөг, чанаргүй зээл 1.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 41.2 хувиар буурч, чанаргүй зээл 6.8 хувиар өссөн байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 1.8 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсч, 90.1 тэрбум төгрөг болжээ.

ЗУРАГ 10. БАНКНЫ ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөгөөр



ЗУРАГ 11. БАНКНЫ ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ, ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО, /мянган хүн, дансны тоогоор/



Улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 132.2 хувьтай байна




Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтсийн мэдээгээр 2023 оны эхний 8 сарын байдлаар орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 109.8 хувьтай буюу 6.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Мөн улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын

төлөвлөгөө 132.2 хувьтай буюу 1.9 тэрбум төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 58.0 тэрбум төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 101.7 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Дэлгэрцогт, Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт, Сайхан-Овоо, Сайнцагаан, Адаацаг сумд 5.2-153.1 хувиар буюу 8.4-396.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол бусад сумд 6.4-26.2 хувиар тасалдуулсан байна.

ЗУРАГ 12. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН БУТЭЦ, хувиар



2023 оны эхний 8 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зарлагын нийт дүн 27.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өсч, 4.8 тэрбум төгрөг болсон нь нийт зардлын 17.2 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өсч, 0.6 тэрбум төгрөг болсон байна.

Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал бусад урсгал шилжүүлэг 80.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 40,7 хувиар тус тус буурсан бол бусад зардал 2.8 хувиас 8.5 дахин өссөн байна.


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өсжээ



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2023 оны 8 сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2 хувиар өсжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 9.2 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 19.5 хувиар, хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис дүнгээрээ 7.2 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 12.8 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 9.9 хувиар, эм тариа эмнэлгийн үйлчилгээний бүлэг 9.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 13. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС /өмнөх оны мөн үетэй харьцуулснаар/



2023 оны 8 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮСНЭГТ 1. ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

№	Барааны нэр, төрөл	VIII/07	VIII/14	VIII/21	VIII/28
1	Гурил, 1-р зэрэг, кг	2 430	2 430	2 430	2 430
2	Хонины мах, кг	9 500	10 000	8 500	10 000
3	Үхрийн мах, кг	16 000	14 000	12 000	14 000
4	Ямааны ястай мах, кг	7 500	8 000	7 000	8 000
5	Элсэн чихэр, кг	4 800	4 800	4 830	4 830
6	Цагаан будаа, кг	3 960	3 960	3 960	3 960
7	Шингэн сүү, л	3 500	3 500	3 500	3 500
8	Ноолуурын үнэ 1 кг	100 000	100 000	100 000	100 000
9	Бензин А-80, 1литр	2 510	2 510	2 510	2 510
10	Бензин А-92, 1литр	2 530	2 530	2 530	2 530
11	Дизель түлш 1 литр	3 600	3 600	3 600	3 600
12	Боодолтой өвс 1 ш	0	0	0	0

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2023 оны эхний 8 сарын байдлаар 31.1 тэрбум төгрөгт хүрчээ



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2023 оны эхний 8 сарын байдлаар 31.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.6 дахин өссөн байна. Энэхүү өсөлтөд уул уурхай олборлох үйлдвэрлэл 3.3 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

I. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2023 оны 08 сарын байдлаар

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
Бүгд	578	297	100.0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	224	109	38.8
Уул уурхай олборлох үйлдвэр	17	2	2.9
Боловсруулах аж үйлдвэр	48	23	8.3
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	2	0	0.3
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	1	0	0.2
Барилга	14	0	2.4
Бөөний ба жижиглэн худалдаа	31	16	0.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1	1	0.2
Зочид буудал, зоогийн газар	10	9	1.7
Мэдээлэл холбоо	6	3	1.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0	0	0.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2	1	0.3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	45	20	7.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	108	55	18.7
Боловсрол	41	36	7.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	14	11	2.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2	2	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12	9	2.1
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0	0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0	0.0

II. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ, 2023 оны 08 сарын байдлаар

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажил хайгч иргэд	Тайлант сарын эцэст байгаа ажил хайгч иргэд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажил хайгч
Дүн	32 721	235	229	133	70
Сайнцагаан	11 073	184	187	112	169
Адаацаг	1 910	1	1	1	5
Баянжаргалан	879	0	0	0	0
Говь-Угтаал	1 060	0	0	0	0
Гурвансайхан	1 548	3	4	1	26
Дэлгэрхангай	1 550	27	3	2	19
Дэлгэрцогт	1 136	8	12	4	106
Дэрэн	1 494	3	5	4	33
Луус	1 385	1	5	2	36
Өлзийт	1 704	2	3	2	18
Өндөршил	1 038	3	3	3	29
Сайхан-Овоо	1 524	0	0	0	0
Хулд	1 704	2	3	1	18
Цагаандэлгэр	701	0	0	0	0
Эрдэнэдалай	4 015	1	3	1	7

III. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВЭРИЙН САНХҮҮЖИЛТ
2023 оны эхний 08 сарын байдлаар, мян.төг

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого			Тэтгэвэрийн санхүүжилт		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Дүн	13 527 576.70	12 097 325.12	89.4	37 026 082.76	37 026 082.76	100.0
Сайнцагаан	7 744 493.11	7 064 961.98	91.2	13 753 291.26	13 753 291.26	100.0
Адаацаг	406 572.29	327 157.66	80.5	1 935 187.79	1 935 187.79	100.0
Баянжаргалан	352 567.23	527 965.54	149.7	805 758.04	805 758.04	100.0
Говь-Угтаал	461 252.56	401 399.46	87.0	1 306 599.51	1 306 599.51	100.0
Гурвансайхан	402 582.34	335 094.90	83.2	1 546 372.34	1 546 372.34	100.0
Дэлгэрхангай	480 668.37	397 491.63	82.7	1 722 949.43	1 722 949.43	100.0
Дэлгэрцогт	310 338.64	267 154.87	86.1	1 412 452.80	1 412 452.80	100.0
Дэрэн	324 971.49	279 668.05	86.1	1 616 097.19	1 616 097.19	100.0
Луус	352 618.16	292 687.69	83.0	1 497 717.49	1 497 717.49	100.0
Өлзийт	441 709.27	375 774.58	85.1	1 867 639.10	1 867 639.10	100.0
Өндөршил	212 316.01	172 611.98	81.3	758 370.23	758 370.23	100.0
Сайхан-Овоо	349 592.49	267 730.58	76.6	1 399 590.60	1 399 590.60	100.0
Хулд	431 228.13	338 365.12	78.5	1 822 688.97	1 822 688.97	100.0
Цагаандэлгэр	365 126.39	305 749.59	83.7	1 111 322.33	1 111 322.33	100.0
Эрдэнэдалай	891 540.22	743 511.49	83.4	4 470 045.68	4 470 045.68	100.0

IV.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА/сая.төг/

	2022 оны VIII сар	2023 оны VIII сар			2023 VIII 2022 VIII хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийгмийн даатгалын сангийн орлого	41 087.80	19 309.81	42 529.58	220.2	103.5
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	37 123.30	17 070.49	37 660.27	220.6	101.4
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 248.80	1 149.02	1 452.27	126.4	116.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1 761.70	.00	2 268.18	0.0	128.7
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	546.80	888.65	720.32	81.1	131.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн	407.20	201.65	428.55	212.5	105.2
Нийгмийн даатгалын сангийн зарлага	39 569.90	41 678.74	41 725.51	41725.5	100.1
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	35 626.90	38 993.80	36 953.49	94.8	103.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 280.50	1 998.60	1 408.67	70.5	110.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1 761.80	.00	2 267.39	0.0	128.7
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	495.10	232.09	665.95	286.9	134.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	405.60	454.25	430.02	94.7	106.0

Тайлбар: *Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

V.НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭРИЙН ХЭМЖЭЭ

Үзүүлэлтүүд	2021 оны VIII сар	2022 оны VIII сар	2023 оны VIII сар	2023 VIII 2022 VIII хувь
Заавал даатгуулагчийн тоо	9 787.00	9 470.00	9 314.00	98.4
Үүнээс				
Аж ахуй нэгж, байгууллага	2 236.00	2 138.00	2 424.00	113.4
Төсөвт байгууллага	3 957.00	3 936.00	3 848.00	97.8
Сайн дурын	3 594.00	3 396.00	3 042.00	89.6
Олгосон тэтгэвэр,	24 678.20	32 920.10	36 950.64	112.2
Үүнээс				
Өндөр настны	21 040.50	28 296.40	31 955.54	112.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	2 227.40	2 843.80	2 887.38	101.5
Тэжээгчээ алдсаны	624.60	819.50	843.33	102.9
Цэргийн	785.70	960.40	1 264.39	131.7

VI. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
Дүн	442	475	159	151	4	4	4	7
Сайнцагаан	418	451	62	72	2	4	2	5
Адаацаг	0	0	9	4	0	0	0	0
Баянжаргалан	1	2	9	6	0	0	0	0
Говь-Угтаал	3	4	5	2	0	0	0	0
Гурвансайхан	0	0	5	5	1	0	1	0
Дэлгэрхангай	6	5	5	7	0	0	0	0
Дэлгэрцогт	0	0	3	6	0	0	0	0
Дэрэн	3	0	6	8	0	0	0	1
Луус	0	0	3	5	0	0	0	0
Өлзийт	3	3	2	3	1	0	1	0
Өндөршил	5	2	12	11	0	0	0	0
Сайхан-Овоо	1	1	6	2	0	0	0	0
Хулд	0	2	5	3	0	0	0	0
Цагаандэлгэр	1	2	2	2	0	0	0	0
Эрдэнэдалай	1	3	25	15	0	0	0	1

VII. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 8 сарын байдлаар

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
									сүрьеэ		Салхин цэцэг	
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
Дүн	7 144	6 981	95 184	114 477	23 704	36 206	3 381	374	16	7	4	142
Сц	3 860	3 749	71 989	89 708	18 885	30 769	1 793	233	8	4	1	95
Ад	249	163	1 899	1 720	136	534	221	39		2		7
Бж	153	111	821	697	71	122	39	2			2	2
Гу	70	120	1 289	1 412	456	791	155	9				2
Гс	59	90	919	1 190	112	308	141	7				4
Дх	176	190	1 061	1 309	44	62	135	3	1			
Дц	176	135	1 632	881	241	147	72	7	2	1		
Дн	152	125	1 326	1 324	189	185	77	6	2		1	1
Лс	180	125	1 973	1 648	160	103	81	5	1			1
Өт	115	104	838	1 572	30	114	184	36				27
Өш	191	196	2 099	1 272	389	317	64	3				
Со	66	86	688	460	323	190	57	7				2
Хд	193	84	763	644	380	164	100	6	1			
Цд	141	111	536	629	263	276	74	3				
Эд	217	310	5 594	7 573	1 865	1 869	188	8	1			1
Мд	254	167	287	171								
Эб	311	261	304	260								
МУЭ төв	581	854	1 166	2 007	160	255						

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

VIII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-1

Үзүүлэлт	2022 VIII	2023 VIII	22/23 хувь
Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо	30773	30578	99.4
Бүх хэрэг	196	185	94.4
Хүнийг санаатай алах гэмт хэрэг	5	0	-
Хүчиндэх гэмт хэрэг	5	3	60.0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	0	2	-
Дээрэмдэх гэмт хэрэг	1	2	200.0
Хүрээлэн байгаа орчны эсрэг	5	0	0.0
Танхайн хэрэг	0	0	-
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	65	73	112.3
Бусдын эд хөрөнгийн хулгай	37	40	108.1
Малын хулгай	10	2	20.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	15	19	126.7
Залилангийн хэрэг	27	29	107.4
Эдийн засгийн гэмт хэрэг	0	0	-
Бусад	26	15	57.7
Эмэгтэй хүн оролцсон	22	22	12.0
Согтуугаар	62	43	69.4
Бүлэглэж	14	3	-
Хүүхэд оролцсон	9	5	55.6
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	15	7	46.7
Хөнгөн	149	163	109.4
	47	22	46.8
Хүнд			
Гэмт хэрэгт холбогдогсод	133	126	94.7
Учирсан бүх хохирол /сая.төг/	827.7	722.7	87.3
Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/	259.9	289.7	111.5
Илрүүлэлтийн хувь	44.9	58.2	129.6
18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/	64	61	95.0

IX. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-2

№	Үзүүлэлтүүд	2022 VIII	2023 VIII	2022/2023 хувь
1	Гэмт хэргийн улмаас:	89	96	107.9
	Нас барсан	12	10	83.3
	Гэмтсэн	77	86	111.7
2	Зам тээврийн осолын улмаас:	13	18	138.5
	Нас барсан	5	7	140.0
	Гэмтсэн	8	11	137.5
3	Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо /Үүнээс/ Эмэгтэй	210	193	91.9
	7 хүртэлх насны	95	68	71.6
	8-13 насны	2	5	250.0
	14-17 насны	8	1	12.5
		12	5	41.7
4	Бүх хүлээн авсан өргөдөл, гомдол мэдээлэл	1191	1061	89.1
	Бүх шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй ӨГМ	390	382	97.9
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	158	129	81.6
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	228	247	108.3
	Харьяаллын дагуу шилжүүлсэн	4	6	150.0
	Үлдэгдэл	27	24	88.9
	Бүх шийдсэнээс 5 хоногт шийдвэрлэсэн	52	51	98.1
	6-ба түүнээс дээш	338	331	97.9
5	Бүх шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн шинжтэй өргөдөл гомдол мэдээлэл /Үүнд/ 5 хоногт	766	646	84.3
	6 ба түүнээс дээш	633	554	87.5
	Үлдэгдэл	133	92	69.2
		8	9	112.5
6	Нийт зөрчил	13355	13218	99.0
7	Илрүүлсэн зөрчил			
	ЗЦТасгаас илрүүлсэн	8799	7698	87.5
	НХЖХТасгаас илрүүлсэн	4556	5520	121.2
8	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасч, торгосон	288	213	74.0
9	Баривчлагдсан хүн	121	134	110.7
10	Журамласан тээврийн хэрэгсэл	357	268	75.1
11	Эрүүлжүүлэгдсэн хүн	209	31	14.8
12	Саатуулагдсан хүн		47	-
13	Зөрчлийн хуулиар арга хэмжээ авагдсан			
	Хүний тоо	12953	12857	99.3
	Мөнгөн дүн /сая.төг/	550.3	626.4	113.8

Х. ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ, сая төгрөг, тоогоор

Үзүүлэлт		Үлдэгдэл		2023/2022 хувь	
		2022 VIII	2023 VIII		
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл		140 620.1	165 920.5	118.0
	Үүнээс	Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	2 521.5	1 482.7	58.8
		Чанаргүй зээлийн үлдэгдэл	1 403.3	1 498.5	106.8
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл		23 931.5	32 459.6	135.6
	Үүнээс	Иргэдийн харилцахын үлдэгдэл	16 279.6	21 544.7	132.3
	Нийт хадгаламжийн үлдэгдэл		82 773.0	90 143.2	108.9
	Үүнээс	Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	82 733.1	90 108.3	108.9
		Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	12 107.8	16 176.1	133.6
		Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	70 665.2	73 967.1	104.7
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо		34	34	100.0
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо		171	160	93.6
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)		24 746	27 035	109.2
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		87 548	90 825	103.7
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		33 154	32 254	113.7
	Нийт АТМ-ны тоо		21	19	90.5
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо		45 313	43 816	96.7

ХI.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	мөр	2022 VIII	2023 VIII			23/22
			төл	гүйц	хувь	хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого /тусламжийн дүн/	1	46 330.7	57 005.7	57 999.2	101.7	125.2
A.Урсгал орлого	2	6 885.3	9 673.8	9 118.9	94.3	132.4
I.Татварын орлого	3	4 850.4	5 612.4	6 165.2	109.8	127.1
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	3 182.2	3 392.3	3 644.1	107.4	114.5
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	5	2 997.9	3 542.6	3 808.6	107.5	127.0
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	6	- 10.8	- 406.7	- 406.7	100.0	3765.7
1.2 үйл ажиллагааны орлого	7	106.1	198.1	155.0	78.2	146.1
1.3 Хөрөнгө борлуулсаны	8	78.3	58.3	84.8	145.5	108.3
1.5 Бусад татвар	9	10.7	.0	2.4	-	22.4
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		.0	198.8	146.7	73.8	-
2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/	10	384.4	86.0	108.9	126.6	28.3
3. Авто тээврийн хэрэгслийн	11	344.9	313.6	295.7	94.3	85.7
4. Бусад татвар	12	938.9	1 621.7	1 969.8	121.5	209.8
4.1 Улсын тэмдэгтийн	13	93.0	98.5	83.3	84.6	89.6
4.2 Ашигт малтмал нөөцийн	14	12.7	40.1	6.6	16.5	52.0
4.3 Газрын төлбөр	15	425.3	401.8	1 059.1	263.6	249.0
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	16	135.0	128.9	75.3	58.4	55.8
4.6 Усны төлбөр	17	135.0	69.5	252.7	363.6	187.2
4.7.Малд ногдуулах татвар	18	.0	773.5	440.7	57.0	-
4.8.Бусад	19	190.9	109.4	52.1	47.6	27.3
II.Татварын бус орлого	20	2 034.9	4 061.4	2 953.7	72.7	101.6
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	21	1 171.2	3 095.2	1 831.0	59.2	156.3
2.2 Бусад нэр заагдаагүй	22	863.7	966.2	1 122.7	116.2	130.0
Б. Хөрөнгийн орлого	23	17.0	31.5	171.8	545.4	1010.6
В.Тусламжийн орлого	24	39 428.4	47 300.4	48 708.5	103.0	123.5
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	25	8 403.1	10 365.9	10 365.9	100.0	123.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих	27	4 851.6	7 319.3	6 975.9	95.3	143.8
Төсвөөс санхүүжих	29	21 364.0	23 266.5	24 989.4	107.4	117.0
Аймаг нийслэлээс авсан татаас	30	4 809.7	5 116.5	5 116.5	100.0	106.4
Сум дүүргээс авсан тэгшитгэл		.0	1 232.2	1 260.8	102.3	-
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	31	6 902.3	9 705.3	9 290.7	95.7	134.6
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	32	1 170.6	1 399.5	1 850.7	132.2	158.1
Аймгийн нийт орлого	33	8 072.9	11 104.8	11 141.4	100.3	138.0

XII. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Сумд	2023 I-VIII			2023 VIII сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дүн	7 328 423.6	8 640 532.0	117.9	978 521.7	1 306 629.4	133.5
Сайнцагаан	3 316 170.2	3 614 819.1	109.0	479 964.1	532 003.5	110.8
Адаацаг	168 750.0	192 560.2	114.1	15 740.0	24 441.9	155.3
Баянжаргалан	266 985.9	647 101.1	242.4	48 550.0	124 778.0	257.0
Говь-Угтаал	278 290.0	255 348.7	91.8	25 350.0	24 453.3	96.5
Гурвансайхан	437 421.8	696 196.9	159.2	61 974.9	91 331.8	147.4
Дэлгэрхангай	328 292.9	295 018.3	89.9	38 566.1	42 015.0	108.9
Дэлгэрцогт	144 618.0	178 945.3	123.7	11 130.0	27 921.6	250.9
Дэрэн	185 773.0	173 861.5	93.6	15 210.0	16 529.8	108.7
Луус	158 440.0	139 341.8	87.9	13 690.0	33 689.6	246.1
Өлзийт	259 135.0	655 791.7	253.1	16 700.0	150 957.2	903.9
Өндөршил	178 321.0	152 979.1	85.8	17 440.0	23 082.7	132.4
Сайхан-Овоо	162 895.0	171 318.9	105.2	23 430.0	29 532.8	126.0
Хулд	187 866.0	171 100.0	91.1	17 570.0	21 538.2	122.6
Цагаандэлгэр	111 120.0	82 041.3	73.8	14 210.0	12 519.7	88.1
Эрдэнэдалай	479 095.0	394 878.6	82.4	49 750.0	41 827.2	84.1
Дундговь	665 249.8	819 229.5	123.1	129 246.6	110 007.1	85.1

XIII. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Зарлагын төрөл	2022 VIII	2023 VIII			2023 VIII/ 2022 VIII
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийт зарлага	25 527.6	42 952.8	27 880.3	64.9	109.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4 662.9	5 632.8	4 793.7	85.1	102.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	553.2	707.1	574.8	85.1	103.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3 012.9	3 669.0	3 423.6	81.3	113.6
Хангамж бараа материалын зардал	235.0	534.6	344.3	64.4	146.5
Норматив зардал	58.8	101.7	62.3	61.3	106.0
Эд хогшил урсгал засварын зардал	235.0	732.3	372.2	50.8	158.4
Томилолтын зардал	64.3	199.4	151.1	75.8	235.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	873.0	949.2	518.0	54.6	59.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1 893.9	4 163.9	2 091.7	50.2	110.4
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	.0	190.5	.0	.0	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20.0	184.5	170.1	92.2	850.5
Засгийн газрын дотоод шилжүүлэг	5 466.2	6 570.5	6 377.2	97.1	116.7
Бусад урсгал шилжүүлэг	464.4	222.9	92.2	41.4	19.9
Хөрөнгийн зардал	7 247.6	16 276.9	7 594.2	46.7	104.8
Эргэж төлөгдөх зээл	740.4	2 817.5	1 314.9	46.7	177.6

XIV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ 8-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/

Нэр төрөл		Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	3 000	2 875	2 870	2 650
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	2 733	2 450	2 630	2 500
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	2 125	1 383	2 145	1 300
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	1 883	1 950	1 830	1 723
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	2 317	2 800	2 517	2 767
6	Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/	6 033	2 800	5 190	4 300
7	Жигнэмэг /наша марка/150-180г, цайны/	2 830	1 950	1 950	1 750
8	Цагаан будаа, задгай, кг	3 963	3 750	3 825	3 733
9	Шар будаа, задгай, кг	3 230	3 417	2 825	3 200
10	Хонины мах, кг	10 000	10 000	12 500	11 333
11	Адууны мах, кг	-	-	13 000	12 333
12	Ямааны мах, кг	9 000	8 000	12 000	9 667
13	Дотор мах, цувдай, цусгүй	5 000	3 000	6 000	6 333
14	Хиам чанасан, 1кг	14 250	-	-	14 667
15	Сүү, задгай, л	3 500	2 500	5 000	3 800
16	Сүү савласан,1л. Шимт сүү	5 147	5 017	5 146	4 900
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	29 000	20 733	25 000	22 500
18	Өндөг,ш,дотоод	563	433	507	500
19	Ургамлын тос, 1литр, Олайна	10 300	10 600	10 970	8 333
20	Өөхөн тос, кг	-	-	500	3 000
21	Шар тос, кг	25 000	32 000	35 000	30 500
22	Цэцгийн тос, задгай, кг	10 133	9 500	9 583	8 667
23	Төмс дотоод, кг	2 097	1 750	1 783	1 800
24	Лууван хятад, кг	2 550	2 233	2 250	3 333
25	Байцаа хятад, кг	2 497	1 733	3 117	3 167
26	Сонгино хятад, кг	3 330	2 600	3 550	3 767
27	Элсэн чихэр, кг, орос	4 830	4 200	4 690	4 267
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	13 580	13 800	15 250	13 200
29	Шоколад, "Alpen gold"	3 697	3 817	3 673	3 417
30	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	2 975	2 883	3 800	2 400
31	Майноз, /Золотой 500г/	6 975	7 050	6 680	6 667
32	Кетчуп, 900г, Чили Полиш	3 067	4 567	3 637	2 967
33	Ногоон цай, Stimo, савласан 90г	3 550	3 700	4 250	3 050
34	Байхуу цай, Lipton, 20 ширхэгтэй	4 630	4 600	4 530	4 200
35	Цагаан архи, 0.75 ARKHI EXPORT	27 567	25 750	27 067	27 620
36	Пиво, "Cass", 0.5л	4 263	4 150	4 013	3 600
37	Янжуур тамхи, /Esse/, саарал	4 000	3 850	3 760	3 483
38	Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи	3 000	2 850	2 317	2 010
39	Бензин, А-80, 1 литр	2 510	2 460	2 395	2 490
40	Бензин, А-92, 1 литр	2 530	2 480	2 547	2 520
41	Дизель түлш, 1 литр	3 600	3 590	3 630	3 620

ХV. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

	2023 VIII 2022 VIII	2023 VIII 2022 XII
ЕРӨНХИЙ ИНДЭКС	109.2	104.7
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	119.5	113.7
01.1 ХҮНСНИЙ БАРАА	120.5	115.0
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	129.4	113.2
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	120.4	130.8
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН	116.3	112.4
01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	124.8	107.7
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	104.2	96.3
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	106.2	99.7
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	101.5	117.3
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	120.2	110.1
01.1.9 БЭЛЭН ХООЛ, ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН	114.9	110.3
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	111.7	103.3
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	107.2	103.9
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	118.7	109.3
02.2 ТАМХИ	102.5	101.5
03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ	112.8	103.3
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	113.1	103.8
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	110.4	105.7
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	113.7	103.8
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	111.0	101.3
03.2 ГУТАЛ	112.5	102.5
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	101.8	100.4
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	102.3	102.3
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	103.7	100.6
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	100.4	100.1
Барааны бүлгээр	2023 VIII 2022 VIII	2023 VIII 2022 XII
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	109.9	104.5
05.1 ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	104.4	100.4
05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	126.2	113.6
05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	100.5	100.3
05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	106.2	101.4
05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	118.7	107.0
05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	122.6	112.1
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	109.0	106.2
06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ	112.7	108.7
06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
07. ТЭЭВЭР	99.3	99.5
07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	103.5	103.5
07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	97.7	98.0
07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.9	100.6
08.2 МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ	102.7	101.7
08.3 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	116.2	106.9
09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	107.7	107.7
09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	122.7	108.6
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	107.0	100.1
11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	107.0	100.1
11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	111.9	103.0
12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	113.7	103.4
12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	101.8	100.5
12.5 ДААТГАЛ	118.7	118.7
12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

XVI. ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН МЭДЭЭ

	Хэмжээний нэгж	2022 XII	2023 он								
			I	II	III	IV	V	VI	VII	VIII	
1. Малын үнэ /мян.төг/											
Тэмээ											
Нас гүйцсэн	эр	тол	1,683.3	1,726.9	1665.0	1709.1	1745.5	1677.3	1695.5	1636.4	1670.0
	эм	тол	1,412.5	1,415.4	1415.0	1404.5	1463.6	1409.1	1315.0	1345.5	1385.0
Өсвөр насны	эр	тол	1,031.8	1,009.1	995.0	975.0	1016.0	1016.0	995.0	990.0	972.2
	эм	тол	990.9	990.0	955.0	935.0	975.0	994.4	970.0	980.0	905.6
Адуу											
Нас гүйцсэн	эр	тол	1,153.60	1,250.0	1250.0	1254.5	1289.1	1334.5	1322.7	1260.0	1345.8
	эм	тол	1,082.30	1,146.2	1110.0	1145.5	1180.9	1226.4	1236.4	1170.0	1204.5
Өсвөр насны	эр	тол	819.2	827.3	754.5	775.0	835.0	825.0	845.0	850.0	872.7
	эм	тол	788.5	772.7	727.3	760.0	805.0	816.7	830.0	835.0	865.0
Үхэр											
Нас гүйцсэн	эр	тол	1569.2	1,576.9	1585.0	1577.3	1603.6	1685.5	1713.6	1645.5	1620.8
	эм	тол	1319.2	1,408.3	1320.0	1372.7	1480.0	1516.4	1536.4	1472.7	1410.0
Өсвөр насны	эр	тол	807.7	783.3	700.0	697.8	732.0	752.0	822.7	790.0	750.0
	эм	тол	773.1	755.6	680.0	670.0	692.0	722.0	790.9	760.0	727.3
Бог мал											
Нас гүйцсэн хонь	эр	тол	212.3	209.6	217.3	220	222.7	259.6	254.6	254.3	233.3
	эм	тол	146.4	158.3	153.6	155.9	164.5	178.7	172.7	175.8	160.8
Нас гүйцсэн ямаа	эр	тол	151.0	157.7	160.9	159.1	161.7	162.5	166.9	159.2	154.6
	эм	тол	111.4	108.8	110.5	108.2	113.7	117.7	128.2	123.8	116.8
2. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ /мян.төг/											
Тэмээний ноос	кг						8.0	8.0	17.0		
Ямааны ноолуур	кг						110.0	115.0	112.0	110.0	100.0
Тэмээний шир	ш	15.0	23.0	25.0	30.0	30.0	0				
Адууны шир	ш	5.0	12.0	10.0	10.0						
-2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир	ш	8.0	10.0	10.0	0						
Хонины ноостой, өлөн гэдэстэй арьс	ш	4.0	2.0	2.0	2.0	2.5	2.5				2.5
Ямааны ноолууртай, өлөн арьс	ш	35.0	42.0	43.0	40.0	35.0	35.0				

XVII. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ ,оны үнээр, сая төгрөг

Аж үйлдвэрийн салбар	2022 VIII	2023 VIII	2023/2022
Нийт дүн	11 965.8	31 082.8	259.8%
Уул уурхай олборлолт	7 785.7	25 625.4	329.1%
Чулуун нүүрс олборлолт	5 999.6	23 201.6	386.7%
Хүрэн нүүрс олборлолт	386.3	117.2	30.3%
Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт	1 399.8	2 306.6	164.8%
Боловсруулах үйлдвэрлэл	1 299.3	1 305.6	100.5%
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	932.4	975.3	104.6%
Малын тэжээлийн үйлдвэрлэл	77.2	108.8	140.9%
Бусад даавуун эдлэл үйлдвэрлэл	44.7	37.7	84.3%
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	20.6	7.7	37.4%
Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	10.9	.0	0.0%
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	97.9	145.8	148.9%
Хэвлэх болон хэвлэлийн туслах үйл ажиллагаа	12.4	8.4	67.7%
Дээр дурдсан ангид ороогүй төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад үйлдвэрлэл	103.2	21.9	21.2%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1 932.0	2 636.3	136.5%
Уур, агааржуулагчийн хангамжийн үйл ажиллагаа	1 932.0	2 636.3	136.5%
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	948.8	1 515.5	159.7%
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	766.7	1 211.4	158.0%
Хог хаягдлыг цуглуулах	182.1	304.1	167.0%

XVIII. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2022 VIII	2023 VIII	2023/2022 хувь
Нүүрс	мян.тн	78.6	381.3	485.1
Жонш	мян.тн	11.7	9.4	80.3
Гөлтгөнө	мян.тн	5.7	16.0	280.7
Дулааны эрчим хүч	мян.гкал	65.7	86.2	131.2
Хүснэгт, маягт	х.д.х	222.3	150.3	67.6
Талх	тн	77.0	87.4	113.5
Нарийн боов	тн	89.9	102.4	113.9
Бялуу	тн	3.2	1.7	53.1
Чихэр	тн	2.9	1.4	48.3
Цэвэр ус	мян.л	1.3	1.8	138.5
Архи	мян.л	13.9	5.5	39.6
Хэрчсэн гурил	тн	18.3	12.1	66.1
Сүү, тараг	мян.л	0.0	0.0	-
Хоормог	мян.л	0.3	0.2	66.7
Ааруул	тн	0.6	0.3	50.0
Түгээсэн цэвэр ус	мян.т ³	129.6	156.5	120.8
Сувагжуулалт	мян.м ³	86.5	104.4	120.7

Мэдээлэл авах холбоосууд:

<http://www.dundgovi.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь:

2023 оны 10 дугаар сарын 15



Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн

дарга Б.Энхтуяа

Утас: (976)-70593777

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн

Ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн

Мэргэжилтэн С.Доржханд

Мэргэжилтэн Н.Давааням

Мэргэжилтэн

Г.Ариунжаргал

Утас: (976)-70593715



/StatisticMGL



Dundgovi@nso.mn



70593715